



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.02.25 № 199

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар улсын төсвийн байгууллага, мэргэжлийн холбоодод санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийн мөнгөөр биеийн тамирын хувцас бэлтгэсэн, ажлын байр давхардуулан гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн, сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулсан, ахмадын сан байгуулаагүй төсвөөс хөрөнгө зарцуулсан, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан 274.0 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.7, 25 дугаар зүйлийн 25.10, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6, 8 дугаар зүйлийн 8.1, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4, 15 дугаар зүйлийн 15.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.21, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал, батлах заавар"-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн

016020416

зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д заасныг үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны А/37 дугаар захирамжаар төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид үндсэн цалингийн 60 хувиар тооцож орон нутгийн нэмэгдэл олгож ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 12,738.3 сая төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 9,057.5 сая төгрөгийг зарцуулж 3,680.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын 2023 оны 14/18 дугаар тогтоолоор 1,273.7 сая төгрөгийн өртөгтэй Өнө орших эрүүл мэндийн төвийн барилгыг балансаас баланст шилжүүлэн авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>624,229,387.32</u>	<u>568,066,844.32</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	388,983,592.32	292,016,930.32
354	Хангамжийн материал	388,983,592.32	292,016,930.32
35410	Бичиг хэргийн материал	1,276,500.00	8,495,000.00
35420	Аж ахуйн материал	177,981,602.32	120,097,132.32
35440	Түлш, шатах тослох материал	3,152,140.00	3,822,200.00
35470	Бусад хангамжийн материал	206,573,350.00	159,602,598.00
36	НӨӨЦИЙН БАРАА	235,245,795.00	276,049,914.00
36300	Тэжээлийн нөөц	-	91,292,100.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	235,245,795.00	184,757,814.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>11,258,088,237.40</u>	<u>14,558,300,603.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,258,088,237.40	14,558,300,603.74
391	Газар		
392	Биет хөрөнгө	10,855,827,237.28	14,156,469,603.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,182,397,793.00	13,146,116,970.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(743,755,961.15)	(968,614,393.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	529,124,800.00	342,124,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(371,112,827.40)	(223,633,627.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	780,003,373.00	1,188,175,477.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(294,379,186.25)	(235,217,025.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	563,836,313.83	725,893,153.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(156,378,811.19)	(204,704,667.79)
39214	Бусад үндсэн хөрөнгө	513,583,347.00	541,948,992.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(147,491,603.56)	(155,620,075.84)
393	Биет бус хөрөнгө	402,261,000.12	401,831,000.16
39301	Програм хангамж	2,150,000.00	2,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,289,999.88)	(1,719,999.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	401,401,000.00	401,401,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>11,882,317,624.72</u>	<u>15,126,367,448.06</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>48,762,749.00</u>	<u>40,921,240.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	48,762,749.00	40,921,240.00
413	Өглөг	48,762,749.00	40,921,240.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	48,762,749.00	-
4136	Бусад өглөг	-	40,921,240.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	40,921,240.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>11,833,554,875.72</u>	<u>15,085,446,208.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	11,833,554,875.72	15,085,446,208.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,702,350,064.19	8,702,350,064.19
51101	Өмч: - төрийн	8,702,350,064.19	8,702,350,064.19
512	Хуримтлагдсан үр дүн	3,086,377,772.05	6,338,269,104.39
51210	Өмнөх үеийн үр дүн	3,086,377,772.05	3,086,377,772.05
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,251,891,332.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	44,827,039.48	44,827,039.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>11,882,317,624.72</u>	<u>15,126,367,448.06</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,787,930,049.00	13,210,852,985.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,223,088.00	4,309,888.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,223,088.00	4,309,888.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,223,088.00	4,309,888.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,223,088.00	4,309,888.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,784,706,961.00	13,206,543,097.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,619,861.00	471,244,797.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,447,650.00	359,639,054.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,101,106.00	19,535,716.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,071,105.00	92,070,027.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,626,087,100.00	12,735,298,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,626,087,100.00	12,735,298,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,487,901,449.52	13,360,977,743.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,487,901,449.52	13,360,977,743.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,611,351,398.27	9,479,149,236.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	577,927,417.00	1,150,784,974.00
210101	Үндсэн цалин	403,849,320.00	598,669,851.00
210102	Нэмэгдэл	89,710,097.00	451,880,542.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	84,368,000.00	100,234,581.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,212,772.07	146,086,855.45
210201	Тэтгэврийн даатгал	51,559,663.24	100,379,144.74
210202	Тэтгэмжийн даатгал	6,066,406.77	11,803,163.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,651,527.80	9,248,930.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,085,048.50	2,241,424.38
210205	Эрүүл мэндийн даатгал	10,850,125.76	22,414,193.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,564,736.63	286,180,081.22
210301	Гэрэл, цахилгаан	22,784,738.63	28,407,122.58
210302	Түлш, халаалт	154,980,082.00	226,080,294.64
210303	Цэвэр, бохир ус	29,799,916.00	31,692,664.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,682,702,091.45	2,639,006,114.00
210401	Бичиг хэрэг	31,958,700.00	37,669,970.00
210402	Тээвэр, шатахуун	90,040,646.00	104,280,576.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,123,037.00	29,191,501.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,512,673.00	56,156,848.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	2,506,067,035.45	2,411,707,219.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,700,000.00	149,027,140.00
210604	Урсгал засвар	78,700,000.00	149,027,140.00
2107	Томилолт, зочны зардал	15,069,000.00	20,640,100.00
210702	Дотоод албан томилолт	15,069,000.00	20,640,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,792,965,201.20	4,251,202,601.50

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,792,965,201.20	4,251,202,601.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,182,210,179.92	836,221,369.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	107,805,000.00	287,997,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,894,033.00	39,471,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,047,511,146.92	508,751,959.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,876,550,051.25	3,881,828,507.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,907,879.00	199,712,709.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,105,968.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,801,911.00	199,712,709.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,800,642,172.25	3,682,115,798.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,800,642,172.25	3,682,115,798.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(699,971,400.52)	(150,124,758.83)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,295,668,301.21	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,295,668,301.21	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,295,668,301.21)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(4,995,639,701.73)</u>	<u>(150,124,758.83)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,787,930,049.00	13,210,852,985.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,223,088.00	4,309,888.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,223,088.00	4,309,888.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,223,088.00	4,309,888.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,223,088.00	4,309,888.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,784,706,961.00	13,206,543,097.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	158,619,861.00	471,244,797.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,447,650.00	359,639,054.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,101,106.00	19,535,716.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,071,105.00	92,070,027.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,626,087,100.00	12,735,298,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,626,087,100.00	12,735,298,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,999,030,405.95	10,420,545,835.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,999,030,405.95	10,420,545,835.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,122,480,354.70	6,538,717,327.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	577,927,417.00	1,150,784,974.00
210101	Үндсэн цалин	355,880,437.00	543,663,862.00
210102	Нэмэгдэл	103,715,316.00	427,195,850.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	98,478,128.00	141,525,262.00
210104	Урамшуулал	19,853,536.00	38,400,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,212,772.07	146,086,855.45

210201	Тэтгэврийн даатгал	51,844,039.98	98,871,256.45
210202	Тэтгэмжийн даатгал	6,308,162.00	11,803,899.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,179,834.00	9,443,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,083,700.00	2,360,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,797,036.09	23,607,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,564,736.63	286,180,081.22
210301	Гэрэл, цахилгаан	22,784,738.63	28,407,122.58
210302	Түлш, халаалт	154,980,082.00	226,080,294.64
210303	Цэвэр, бохир ус	29,799,916.00	31,692,664.00
2104	Хангамж, бараа материалын зардал	175,492,708.00	204,740,655.00
210401	Бичиг хэрэг	28,734,500.00	44,888,470.00
210402	Тээвэр, шатахуун	70,714,386.00	66,366,636.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,123,037.00	29,191,501.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,920,785.00	64,294,048.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,700,000.00	147,326,040.00
210604	Урсгал засвар	78,700,000.00	147,326,040.00
2107	Томилолт, зочны зардал	15,069,000.00	20,640,100.00
210702	Дотоод албан томилолт	15,069,000.00	20,640,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,858,665,788.00	4,247,564,961.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,858,665,788.00	4,247,564,961.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,847,933.00	335,393,660.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	107,805,000.00	295,921,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,042,933.00	39,471,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,876,550,051.25	3,881,828,507.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,907,879.00	199,712,709.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,105,968.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,801,911.00	199,712,709.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,800,642,172.25	3,682,115,798.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,800,642,172.25	3,682,115,798.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,788,899,643.05	2,790,307,150.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,786,873,138.05	2,772,106,703.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,786,873,138.05	2,772,106,703.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,786,873,138.05	2,772,106,703.00
223001	Бусад хөрөнгө	2,428,145,693.05	2,382,968,515.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	358,727,445.00	389,138,188.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,786,873,138.05)	(2,772,106,703.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,026,505.00	18,200,447.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	8,702,350,064.19	44,827,039.48	3,086,377,772.05	11,833,554,875.72

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,702,350,064.19	44,827,039.48	3,086,377,772.05	11,833,554,875.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	3,251,891,332.34	3,251,891,332.34
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,702,350,064.19	44,827,039.48	6,338,269,104.39	15,085,446,208.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,738,299,300.00	9,057,492,389.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,216,517,800.00	6,397,746,886.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,166,517,800.00	6,347,825,231.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,180,388,000.00	1,150,784,974.00
210101	Үндсэн цалин	557,396,000.00	543,663,862.00
210102	Нэмэгдэл	432,792,000.00	427,195,850.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	151,800,000.00	141,525,262.00
210104	Урамшуулал	38,400,000.00	38,400,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,549,500.00	146,086,855.45
210201	Тэтгэврийн даатгал	100,333,900.00	98,871,256.45
210202	Тэтгэмжийн даатгал	11,803,900.00	11,803,899.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,443,100.00	9,443,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,360,800.00	2,360,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,607,800.00	23,607,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	342,752,000.00	286,180,081.22
210301	Гэрэл, цахилгаан	39,000,000.00	28,407,122.58
210302	Түлш, халаалт	254,252,000.00	226,080,294.64
210303	Цэвэр, бохир ус	42,000,000.00	31,692,664.00
210304	Байрны түрээс	7,500,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	266,000,000.00	198,499,119.00
210401	Бичиг хэрэг	72,000,000.00	43,936,470.00
210402	Тээвэр, шатахуун	86,400,000.00	61,077,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,600,000.00	29,191,501.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	74,000,000.00	64,294,048.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000,000.00	224,777,240.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	90,000,000.00	85,951,200.00
210604	Урсгал засвар	160,000,000.00	138,826,040.00
2107	Томилолт, зочны зардал	36,801,000.00	19,776,100.00
210702	Дотоод албан томилолт	36,801,000.00	19,776,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,884,027,300.00	4,269,424,961.50

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,884,027,300.00	4,269,424,961.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,000,000.00	52,295,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,894,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,000,000.00	37,401,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,000,000.00	49,921,655.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,000,000.00	49,921,655.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000,000.00	49,921,655.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,521,781,500.00	2,659,745,503.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,521,781,500.00	2,659,745,503.00
223001	Бусад хөрөнгө	4,521,781,500.00	2,659,745,503.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,735,298,300.00	9,057,492,389.17
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,735,298,300.00	9,053,182,501.17
132001	Орон нутгийн төсвөөс	12,735,298,300.00	9,053,182,501.17
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	4,309,888.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,309,888.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	448,494,350.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,494,350.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	298,703,296.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,241,536.00
210401	Бичиг хэрэг	952,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,289,536.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00
210604	Урсгал засвар	8,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	864,000.00
210702	Дотоод албан томилолт	864,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	283,097,760.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	281,027,760.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,070,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,791,054.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	149,791,054.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	149,791,054.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	471,244,797.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	471,244,797.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	359,639,054.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,535,716.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	92,070,027.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38,309.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 38,309.6 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг 38,309.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 274,030.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2,660.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 121,878.5 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 149,492.0 мянган төгрөгийн зөрчилд хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 6 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны А/168, А/185 дугаар тушаалаар "Уран биндэр" ХХК-д төсвөөс 2,660.0 мянган төгрөг шилжүүлж, байгууллагын албан хаагчдад төсвийн хөрөнгөөр тэмцээн, уралдааны хувцас хийлгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно"-д заасантай нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

Тухайн онд төсвийн хөрөнгөөр худалдан авах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, "Бэ Еэ Дэ" ХХК, "АЙ СИ БИ СИ" ХХК, "СОРОС ЭЛЕКТРОНИКС" ХХК-аас шууд гэрээгээр 69,710.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

ЗДТГ нь батлагдсан орон тооны архив, бичиг хэргийн ажилтнаас гадна, давхар иргэн Я.Сарантуяатай архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх гэрээ байгуулж, ажлын хөлсөнд 10,800.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Засаг даргын 2023 оны А/297 дугаар захирамж, байгууллагын даргын 2023 оны А/157, А/176 дугаар тушаалаар багш нарын баяр, ахмадын баяр, шинэ жилийн баярын арга хэмжээнд зориулан 17,418.5 мянган төгрөгийн хөрөнгийг төсвөөс зарцуулсан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно"-д заасантай нийцэхгүй байна.

Байгууллагын даргын 2023 оны А/161 дүгээр тушаалаар хичээл үйлдвэрлэлийн зардлаас 3,000.0 мянган төгрөгөөр ажилчдад бүжгийн сургалтад хамруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал, батлах заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

Засаг даргын 2023 оны А/456 дугаар захирамж, байгууллагын даргын 2023 оны А/186 дугаар тушаалаар нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас тамгын газрын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих арга хэмжээнд 12,400.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2 "өөрийн байгууллагын ажилтны эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу зохион байгуулах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Байгууллагын даргын 2023 оны А/168 дугаар тушаалаар "Зүүн бүсийн төрийн албан хаагчдын уулзалт, зөвлөгөөн"-д 7,610.0 мянган төгрөг, Их замын хурд ХХК-д авто машин угаалгын хөлсөнд 940.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: 1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сурталчлах ажлын гэрээг "Говийн мэдээллийн хөтөч ХХК"-тай шууд гэрээ байгуулж, хэсэгчлэн хувааж баг тус бүрээр гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгссөн зөвлөмж: Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зөрчлийг арилгах

Илрүүлэлт: 2 Засаг даргын захирамжаар орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас Онцгой байдлын газар, Политехникийн коллеж, Хөгжимт жүжгийн театр, Зэвсэгт хүчний 167 дугаар цэргийн анги, Цагдаагийн хэлтэс, УЦУОША-д нийтдээ 48,540.5 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй, нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах

Илрүүлэлт:3 Кээн Пикдерс ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд Засаг даргын нөөц сан болон ЗДТГ-ын үндсэн данснаас хэвлэл мэдээллийн төлбөрт 4 удаагийн ажил гүйцэтгэх гэрээгээр нийтдээ 30,000.0 мянган төгрөгийг ажлын хөлсөнд олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хэвлэл мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зөрчлийг арилгаж ажиллах

Илрүүлэлт:4 Байгууллагын даргын 2023 оны А/169 дугаар тушаалаар байгууллагын албан хаагчдын идэвхийг нэмэгдүүлэх, ISO стандартын дотоод сургалт зохион байгуулахад 3,000.0 мянган төгрөгийг "Зорилготой бүсгүйчүүд" НҮТББ-д шилжүүлсэн байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

Илрүүлэлт:5 Нийт бүжгийн аяс холбоо, Монголын хараагүйчүүдийн холбоо, Монголын Баристагийн холбоо, аймгийн Боксын холбоонд тус тус нийт 11,803.0 мянган төгрөгийн хандив, тусламж үзүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.21 "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх

Илрүүлэлт:6 ЗДТГ-ын Тамгын газрын 2023 оны А/17 дугаар тушаалаар нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлэх зардалд 6,298.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмадын сан байгуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны А/168, А/185 дугаар тушаалаар "Уран биндэр" ХХК-д төсвөөс 2,660.0 мянган төгрөг шилжүүлж, байгууллагын албан хаагчдад төсвийн хөрөнгөөр тэмцээн, уралдааны хувцас хийлгэсэн байна.	1	2,660.0	1	2,660.0									
Тухайн онд төсвийн хөрөнгөөр худалдан авах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, "Бэ Еэ Дэ" ХХК, "АЙ СИ БИ СИ" ХХК, "СОРОС ЭЛЕКТРОНИКС" ХХК-аас шууд гэрээгээр 69,710.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.	1	69,710.0			1	69,710.0							
ЗДТГ нь батлагдсан орон тооны архив, бичиг хэргийн ажилтнаас гадна, давхар иргэн Я.Сарантуяатай архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэх гэрээ байгуулж, ажлын хөлсөнд 10,800.0 мянган төгрөг олгосон байна.	1	10,800.0			1	10,800.0							
Засаг даргын 2023 оны А/297 дугаар захирамж, байгууллагын даргын 2023 оны А/157, А/176 дугаар тушаалаар багш нарын баяр, ахмадын баяр, шинэ жилийн баярын арга хэмжээнд зориулан 17,418.5 мянган төгрөгийн хөрөнгийг төсвөөс зарцуулсан байна.	1	17,418.5			1	17,418.5							
Байгууллагын даргын 2023 оны А/161 дүгээр тушаалаар хичээл үйлдвэрлэлийн зардлаас 3,000.0	1	3,000.0			1	3,000.0							

мянган төгрөгөөр ажилчдад бүжгийн сургалтад хамруулсан байна.												
Засаг даргын 2023 оны А/456 дугаар захирамж, байгууллагын даргын 2023 оны А/186 дугаар тушаалаар нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас тамгын газрын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих арга хэмжээнд 12,400.0 мянган төгрөг олгосон байна.	1	12,400.0			1	12,400.0						
Байгууллагын даргын 2023 оны А/168 дугаар тушаалаар "Зүүн бүсийн төрийн албан хаагчдын уулзалт, зөвлөгөөн"-д 7,610.0 мянган төгрөг, Их замын хурд ХХК-д авто машин угаалгын хөлсөнд 940.0 мянган төгрөг зарцуулсан байна.	1	8,550.0			1	8,550.0						
Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сурталчлах ажлын гэрээг "Говийн мэдээллийн хөтөч ХХК"-тай шууд гэрээ байгуулж, хэсэгчлэн хувааж баг тус бүрээр гүйцэтгүүлсэн байна.	1	49,850.0					1	49,850.0				
Засаг даргын захирамжаар орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас Онцгой байдлын газар, Политехникийн коллеж, Хөгжимт жүжгийн театр, Зэвсэгт хүчний 167 дугаар цэргийн анги, Цагдаагийн хэлтэс, УЦУОША-д нийтдээ 48,540.5 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	1	48,540.5					1	48,540.5				
Кээн Пикдерс ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд Засаг даргын нөөц сан болон ЗДТГ-ын үндсэн данснаас хэвлэл мэдээллийн төлбөрт 4 удаагийн ажил гүйцэтгэх гэрээгээр нийтдээ 30,000.0 мянган төгрөгийг ажлын хөлсөнд олгосон байна.	1	30,000.0					1	30,000.0				
Байгууллагын даргын 2023 оны А/169 дугаар тушаалаар байгууллагын албан хаагчдын идэвхийг нэмэгдүүлэх, ISO стандартын дотоод сургалт зохион	1	3,000.0					1	3,000.0				

байгуулахад 3,000.0 мянган төгрөгийг "Зорилготой бүсгүйчүүд" НҮТББ-д шилжүүлсэн байна.												
Нийт бүжгийн аяс холбоо, Монголын хараагүйчүүдийн холбоо, Монголын Баристагийн холбоо, аймгийн Боксын холбоонд тус тус нийт 11,803.0 мянган төгрөгийн хандив, тусламж үзүүлсэн байна.	1	11,803.0					1	11,803.0				
ЗДТГ-ын Тамгын газрын 2023 оны А/17 дугаар тушаалаар нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлэх зардалд 6,298.6 мянган төгрөг зарцуулсан байна.	1	6,298.6					1	6,298.6				
Дүн	13	274,030.6	1	2,660.0	6	121,878.5	6	149,492.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудит

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Аудитаар зөрчил илрээгүй байна.									
ДҮН									

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг 38,309.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна	1	38,309.6			1	38,309.6						
Дүн	1	38,309.6			1	38,309.6						

